



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 30 өдөр

Дугаар А/663

Мандалговь

Худалдан авах ажиллагааны газар
байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн "Аймгийн Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай" 377 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.26, 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн "Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 312 дугаар тогтоол 1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг "Худалдан авах ажиллагааны газар"-ыг 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөр байгуулсугай.
2. Орон нутгийн өмчийн газраас худалдан авах ажиллагаа хариуцсан албан хаагчдыг цалингийн сан, эд хөрөнгийн хамт 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсүгэй.
3. Худалдан авах ажиллагааны газрын бүтэц, орон тооны зохион байгуулалтын бүтцийг нэгдүгээр, албан тушаалын жагсаалтыг хоёрдугаар, газрын дүрмийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

ЗАСАГ ДАРГА




Ц.МӨНХБАТ

4823101561

Аймгийн Засаг даргын 2023 оны
11 сарын 30 өдрийн 16 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

Худалдан авах ажиллагааны газрын бүтцийн схем



Аймгийн Засаг даргын 2023 оны
11 сарын 3 өдрийн 14 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

Худалдан авах ажиллагааны газрын албан
тушаалын жагсаалт

Д/д	Албан тушаалын нэршил	Албан тушаалын төрөл	Албан тушаалын ангилал, зэрэглэл	Орон тоо
1	Худалдан авах ажиллагааны газрын дарга	Удирдах	Ахлах түшмэл, ТЗ-4	1
2	Худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл, ТЗ-8	1
3	Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл, ТЗ-9	3
5	Дотоод хяналт, шалгалтын мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл, ТЗ-9	1
	Орон тоо			6